

## Хэвлэлийн мэдээ

№:14-25

2014 оны 12 дугаар сарын 5

### **20 дахь удаагийн “Японоор хэн сайн ярих вэ” уралдаан зохион байгуулагдана**

Хэвлэлийн мэдээ

1. 12 дугаар сарын 13-ны Бямба гарагийн 13 цагаас Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (Монгол-Япон төв)-д 20 дахь удаагийн “Японоор хэн сайн ярих вэ” уралдаан зохион байгуулагдах гэж байна.
2. Энэхүү уралдааныг Япон улсын Элчин сайдын яам, Монголын япон хэлний багш нарын холбоо, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв хамтран зохион байгуулдаг бөгөөд энэ удаагийн уралдааныг Монгол дахь япончуудын холбоо ивээн тэтгэж байна.
3. Сүүлийн жилүүдэд Монгол, Япон хоёр орны харилцаа олон салбарт улам бүр өргөжин хөгжиж байна. Энэхүү уралдаан нь Монголын хүүхэд залуучуудын япон хэл сурах хүсэл сонирхлыг дэмжин урамшуулах зорилготой юм. Уралдаанд оролцох япон хэл суралцагч ахлах ангийн сурагчид, их сургуулийн оюутнууд япон хэлээр илтгэх ур чадвараараа өрсөлдөх болно. Үнэ төлбөргүй үзэх боломжтой тул та бүхэн өргөнөөр хүрэлцэн ирж үзэж сонирхоно уу.
4. Уралдаан 13 цагт нээлтээ хийх ба 16:45 цагаас ялагчдад шагнал гардуулах ёслол болох тул хэвлэл мэдээллийнхэн та бүхнийг хүрэлцэн ирж сурвалжлахыг урьж байна.

Жич: Монгол-Япон төвийн хашааны урд хаалга барилгын ажлын улмаас хаалттай байгаа тул та бүхэн МУИС-ийн 1 дүгээр байрны баруун талын аркаар орж, тус төвийн хашааны хойд хаалгаар ирнэ үү.

---

**ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ**

ЛАВЛАХ УТАС:320777